



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 206 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 331,224,974.00 (гурван зуун гучин нэгэн сая хоёр зуун хорин дөрвөн мянга есөн зуун далан дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Авлигатай тэмцэх газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дэд дарга Д.Хулганажав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Хавсралтад заасан хөрөнгийн элэгдлийг нөхөн тооцож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу данс бүртгэлд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



000001



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 сарын 29 -ний өдрийн
422 дугаар тогтоолын хавсралт

ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРААС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн нэр (англи/	Ашигла л тад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Хурлын дижитал удирдлагын төхөөрөмж	Fully Digital Congress System Main Unit	2016	ш	2	12,035,000.00	24,070,000.00
2	Микрофоны нэмэлт удирдлагын төхөөрөмж	Fully Digital Congress System Extension Main Unit	2016	ш	1	3,706,780.00	3,706,780.00
3	Хуралд оролцогчийн микрофон	Fully Digital Congress System Delegate Unit	2016	ш	80	1,612,690.00	129,015,200.00
4	Дуу, дүрсийн бичигч	Professional Audio & Video Recorder for Conference	2016	ш	1	6,916,400.00	6,916,400.00
5	Орчуулгын төхөөрөмжийн удирдлага	16 CHs Digital Infrared Transmitter	2016	ш	1	8,593,000.00	8,593,000.00
6	Дууны гаралтын төхөөрөмж	8 Channels Audio Output Device	2016	ш	2	5,639,607.00	11,279,214.00
7	Дууны хувиарлагч	1x10 Broadcast Standard Audio Distributor	2016	ш	2	2,140,920.00	4,281,840.00
8	Орчуулгын радиотар	35W Digital Infrared Radiator	2016	ш	2	8,166,960.00	16,333,920.00
9	Хүлээн авагчийн зай	32 CHs Digital Infrared Receiver	2016	ш	100	654,360.00	65,436,000.00
10	2 чихний хүлээн авагчийн чихэвч	Headphone	2016	ш	100	50,160.00	5,016,000.00

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн нэр /англи/ Pack	Ашигла л тэд орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)
11	Хүлээн авагчийн зай	Ni-MH Rechargeable Battery	2016	ш	100	54,720.00	5,472,000.00
12	Хүлээн авагч цэнэглэгч хайрцаг	IR Receiver Charging Case	2016	ш	2	5,289,600.00	10,579,200.00
13	Хүлээн авагчийн хадгалах хайрцаг	IR Receiver Storage Case	2016	ш	1	1,279,080.00	1,279,080.00
14	Орчуулагчийн микрофон	Fully Digital Congress System Interpreter Unit	2016	ш	2	3,135,000.00	6,270,000.00
15	Орчуулагчийн чихэвч	Interpreter headset	2016	ш	2	351,120.00	702,240.00
16	40 м 6-pin Extension Кабель	40 m 6-pin Extension Cable	2016	ш	2	565,440.00	1,130,880.00
17	10 м 6-pin Extension Кабель	10 m 6-pin Extension Cable	2016	ш	1	157,320.00	157,320.00
18	5 м 6-pin Extension Кабель	5 m 6-pin Extension Cable	2016	ш	2	93,480.00	186,960.00
19	Кабель Coaxial-cable	Coaxial-cable	2016	ш	2	9,120.00	18,240.00
20	Чанга яригч	linear array speaker	2016	ш	4	601,750.00	2,407,000.00
21	Өсгөгч	Linear array amplifier	2016	ш	2	722,100.00	1,444,200.00
22	Device rack 42U	Device rack 42U	2016	ш	1	1,564,500.00	1,564,500.00
23	Device rack 12U	Device rack 12U	2016	ш	1	365,000.00	365,000.00
24	Орчуулагчийн кабин	Interpreter Booth	2016	ш	1	25,000,000.00	25,000,000.00
	Дүн				414		331,224,974.00
							(гурван зуун гучин нэгэн сая хоёр зуун хорин дөрвөн мянга есөн зуун далан дөрвөн)